

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2023 оны 09 дугаар сарын мэдээ

2023.09.25

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, цагдаагийн тасагтай хамтарч ЕБС-ийн сурагчдын дунд “Болгоомж илүүдэхгүй” аяныг 14 хоногийн хугацаанд явуулж шинээр гарсан хууль тогтоомжийн талаар сургалт мэдээлэл хийж, ЕБС-ийн сурагчдын дунд 9 хүүхдийн бүрэлдэхүүнтэй “Гэрэлт ирээдүй” бүлгэм байгуулж ажилласан.

б/ **Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:** Тухайн сард дээд газраас 15 албан бичиг ирсний 2 нь хариутай, хугацаа хоцорсон албан бичиг байхгүй болно.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 261 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Шинэ суурьшлын бүсэд 04 шугам"-ын өргөтгөлийн ажлын тендерт "Гранд эрчим" ХХК шалгарч ажлыг зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэн 2023 оны 09 дүгээр сарын 08 -ны өдөр ДБЭХС ТӨХК-ны Сүхбаатар аймаг дахь салбарын ахлах инженер Г.Төрмөнхөөр ахлуулсан ажлын хэсэг ирж хүлээн авлаа.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар "Дэлгэр багийн төв"-ийг шинээр барих барилгын ажлын тендерт "Оточ оргил" ХХК шалгарч барилгын ажлыг зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэн 2023 оны 09 дүгээр сарын 14 -ны өдөр ажил хүлээн авах сумын комисс очиж ажиллаж барилгыг хүлээн авлаа.

Хоёр: **Төсөв санхүүгийн чиглэлээр:** 2023 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ.

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг , Тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг хуваарийн дагуу төсвийн орлоготой уяалдуулан олгосон. Дутуу өгсөн санхүүжилтийг цалингийн ашгийн орлого сарын эцэст орж ирхээр хуваарилахаар төлөвлөн ажиллаж байна.

Байгууллагын өр авлага ,төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн .

Статистикийн байгууллагад хүргүүлэх сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж явуулсан. Мөн малын ашиг шимийн судалгааг 6 багт хийж, амьдрах орчны судалгааг 3 багт хийж цаг хугацаанд нь хүргүүлсэн.

Төсөвт байгууллагуудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

Аймгийн төрийн сангийн үүрэг чилэлийн дагуу төсөвт байгууллагуудын холбогдох дансыг нягтлан бодогч нараар татварын системд бүртгэлийг шинэчлүүлсэн.

ОНХСан , малын тоо толгойн албан татвараар хийгдэх ажил болон засаг даргын мөрийн хөтөлбөрөөр хийгдсэн ажлуудын санхүүжилт хуваарын дагуу олгогдож цаг хугацаандаа хийгдсэн.

Сар бүр орон нутгийн ерөнхий орлогыг тухай бүрт холбогдох дансруу хааж бичилтийг хийж гүйцэтгэж байна.

Төсвийн багц болон төсвийн хэлбэлзэлийг сар бүр хэвлэн архивлаж, сар бүр ЭМТ, Соёлын төв, ЗДТГ-ын санхүүжилт олгох болон нэмэлт санхүүжилтын хөтөлбөр зориулалтыг журмын дагуу бичилт хийж байна.

ОНХС-ын хийгдсэн ажлын төлөвлөгөө, ажлын хэсгийн жагсаалтыг программ-д шивж оруулсан байна.

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дүгнэлт зөвлөмжийн дагуу биелэлтийг аудитын байгууллагын цахим системд шивж оруулан илгээсэн.

Гурав. **Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:** Онцгой байдлын газрын орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг тус суманд гамшгаас хамгаалах "Команд штабын дадлага, сургууль" амжилттай зохион байгууллаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Хүүхдийн цэцэрлэг: 09 дүгээр сарын 01 нд нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж цэцэрлэгийн хэмжээнд нийт 257 хүүхдийг өдрийн бүлэгт хүлээн авч сургалт үйл ажиллагаа жигдэрч байна.

Эцэг эхийн уулзалтыг зохион байгуулж цэцэрлэг, багш, эцэг эхийн гурвалсан гэрээг байгуулж. БШУЯ-наас баталсан сурагчдын сургалтын болон ариун цэврийн хэрэгслийг бүрэн авч дуусгалаа.

Эрт илрүүлгийн үзлэгт 9 багшийг Улаанбаатар хотод Монгол-Японы хамтарсан эмнэлэгт үзүүлж шинжилгээнд хамруулсан.

“Эцэг эхийн уулзат” өдөрлөгийг 09 сарын 29 нд зохион байгуулахаар төлөвлөж байна. Уг өдөрлөгөөр цэцэрлэгийн үйл ажиллагаа, шинэ гарсан хуулийн танилцуулга, хоолны амалгаа зэргийг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Соёл: 2023 оны 9 сард соёл урлагийн 10 үйл ажиллагаа зохион байгуулж 1393 хүн хамрагдлаа. Соёлын ажилтны 30 дах өдрийг тохиолдуулан Соёлын биет бус өв тээгчидийн бүтээлээр үзэсгэлэн гаргаж 102 хүн үзэж сонирхлоо. Мөн дунд ангийн сурагчдын дунд “Шахаар наадъя” шагай шүүрэх тэмцээнийг зохион байгуулж эхний гурван байрыг шалгаруулж хичээлийн хэрэгслийн багцаар шагнаж урамшууллаа.

Соёлын төвийн дэргэдэх “Бидний урлан” зургийн дугуйлангийн бүртгэл хийгдэж 30 хүүхэдтэйгээр дугуйлан хичээллэж эхэлсэн.

Эрүүл мэнд: Нийт үзлэгт- 671 үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг – 392, Больникод хэвтэн эмчлүүлсэн нийт – 45, Үүнээс: 0-5 насны хүүхэд – 11. Алсын дуудлага – 22, Аймгийн нэгдсэн эмнэлэгт 4 удаа өвчтөн тээвэрлэсэн байна. Ирсэн дуудлага бүрийг хугацаа алдалгүй шийдвэрлэсэн

“Болгоомж илүүдэхгүй” аянд нэгдэж нийт 50 гарын авлага тарааж рентгенд 35 хүнийг харж зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.

ЕБСургууль: “Чадварлаг багш” хөтөлбөрийн хүрээнд багш бүрийг компьютержуулах төсөл хэрэгжиж, Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 90,0 сая төгрөгийн хөрөнгөөр өндөр хүчин чадал, үзүүлэлт сайтай 30 ширхэг зөөврийн компьютерыг хүлээлгэн өгсөн.

МУГБ Г.Батболд ахмад багш нарын төлөөлөл "Сүхбаатар аймгийн боловсролын түүхэн ном" бүтээх ажлын хүрээнд үе үеийн удирдлага, багш, ажилчидтай уулзаж, мэдээллүүд авлаа. Мөн бага ангийн багш нарт мэдээлэл хүргэж зөвлөгөө өглөө.

Өсвөрийн сэргийлэгч "Гэрэлт ирээдүй" бүлгэмийн хүүхдүүд Сумын цагдаагийн үйл ажиллагаатай танилцаж ахлагчаа томилж цаашид хийх ажлаа ярилцлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад 2023-2024 оны хичээлийн жилд баримтлах чиглэлийн 1.8-д заасны дагуу 6 настай хүүхдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үзлэгийг сумын эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулж 1-р ангийн суралцагчдыг бүрэн хамрууллаа.

2023-2024 оны хичээлийн жилд ЕБС-ийн 5,6 дугаар ангид хэрэгжих англи хэлний "PEARSON" хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарах, дэмжин хамтрах зорилгоор мэргэжлийн багш нар эцэг эхийн хурал хийн, хөтөлбөрийг танилцуулан сурагчид гэртээ даалгавраа хийх нөхцөл бүрдүүлж, хяналт тавин хамтран ажиллахыг уриалав.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчны чиглэлээр: Орон нутгийн төсвийн 20 000 000 төгрөгийн хөрөнгөөр сумын нэгдсэн хогийн цэгийг булж устган, шинээр 5х20 м хэмжээтэй хог хаягдлын нүх, мал нядалгааны үйл ажиллагаа явуулдаг Баяндэлгэр хүнс ХХК, болон хувийн аж ахуй нэгжүүдтэй хамтран 5х15м хэмжээтэй 2 нүхийг үйл ажиллагааны хог хаягдлыг зайлуулахаар ухаж бэлтгээд байна.

Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модны ургалтад мониторинг хийх, үнэлэлт өгөх ажлын хэсгийг сумын засаг даргын захирамжаар шинэчлэн байгуулсан.

Тухайн ажлын хэсэг 2023 оны 09 дүгээр сарын 13 ны өдрөөс 19 ний өдрийг хүртэлх хугацаанд сумын хэмжээнд 5 ногоон байгууламжийн хашаанд 2022-2023 онд тарьж ургуулж буй нийт модыг тоолон мониторингийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

Ажлын хэсгийн дүнгээр 2022 онд тарьсан модны амьдралтын хувь 88 хувьтай, 2023 онд тарьсан модны амьдралтын хувь 87 хувьтай байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Тухайн суманд жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ хоршоог хөгжүүлэх бодлогын хүрээнд үйлдвэр үйлчилгээ эрхэлдэг ААН, иргэдийн үйл ажиллагааг дэмжиж бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгоор хоршоо хөгжүүлэх хөнгөлөлттэй зээл олгох төслийг 2023 оны 08 дугаар сарын 22 ноос 09 дүгээр сарын 22 ны өдөр хүртэл 1 сарын хугацаатай зарлаж 8 төслийг хүлээн авч судалж байна.

Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах зорилгоор тус сумын 2 иргэн хадланд гарч өвс бэлтгэн малчдаас захиалга авч байна. Малчдын түвшинд 105 тн өвс бэлтгэсэн.

Үндэсний үйлдвэрлэл 2023 арга хэмжээний хүрээнд **"Намрын ногоон өдөр-Баяндэлгэр 2023"** үзэсгэлэн худалдааг 2023 оны 09 дүгээр сарын 27 ны өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган тус арга хэмжээнд оролцох үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүртгэлийг хийж байна.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн